



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04 сарын 09

Дугаар 01

Улаанбаатар хот

"Материалимпэкс" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Г.Аюушмаа даргалж, хувьцаа эзэмшигч Б.Зориг /768062/, Г.Аюушмаа /524/, У.Акбопе /67/, У.Женисгул /67/, У.Ценгелхан /68/, У.Гүлжайна /68/, У.Батырбек /67/, У.Хузыр /68/ нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Хизатбек, Т.Мөнхжаргал /119/, Ж.Энхтунгалаг /1/, "Би Ди Сек ҮЦК" ХК /9659/-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Онон, Б.Ганболд /1/, Г.Гансүх /238/, "Ард капитал групп ҮЦК" ХК /563/-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.Баярмаа, С.Мягмарсүрэн /2/, хурлын тэмдэглэл хөтлөх нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуун нарыг оролцуулан "Материалимпэкс" ХК-ийн танхимд 2019 оны 04 сарын 09-ний өдрийн 10 цаг 40 минутад хийв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ч.Энхтуул, гишүүн Ч.Чинзориг, гишүүн Н.Мягмарсүрэн, гишүүн - хувьцаа эзэмшигч Б.Зориг, Г.Аюушмаа, Т.Мөнхжаргал нар оролцсон болно/

Даргалагчаас: Хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлээд, ХЭ-ийн ээлжит хурлын дэгийг танилцуулаад хүн бүрийн өмнө хурлын материал, дарааллыг хавтаслаад тавьсан байгаа. Урьдчилан танилцаад асууж тодруулах зүйлээ бэлдээд ирсэн байх аа. Хурал эхлэхээс өмнө тооллогын комиссын ирцийн мэдээ сонсоно. Өмнө нь хурлын тооллогын комиссын гишүүдийг танилцуулъя. Тооллогын комиссын дарга Т.Байгаль нь тус компанийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст тээврийн менежерээр ажилладаг, манай компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдтэй ямар нэгэн садан төрлийн болон ашиг сонирхлын зөрчилгүй, манай компанийн хувьцаа эзэмшдэггүй, тооллогын комиссын гишүүн Т.Чойжамц нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, Гадаадын хөрөнгө оруулалттай "Кунлунгуотай инвестментс" ХХК-д нягтлан бодогчоор ажилладаг, манай харилцагч байгууллагын ажилтан хүн байна. Н.Түмэндэмбэрэл мөн нягтлан бодогч мэргэжилтэй "Материал Гласс" ХХК-ийн нягтлан бодогчоор ажилладаг, манай байгууллагатай харилцаа холбоотой ажилладаг. Энэхүү 2 гишүүн нь мөн адил компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдтэй ямар нэгэн садан төрлийн болон ашиг сонирхлын зөрчилгүй, компанийн хувьцаа эзэмшдэггүй бөгөөд энэ талаараа өөрсдөө баталгаа гаргаж өгсөн байгаа. Эдгээр хүмүүс өнөөдрийн хурлын тооллогын комиссоор томилогдсон байна. Одоо цаг 10 цаг 50 минут болж байна, комиссын дарга, гишүүд ирцийн бүртгэлийг дуусгаж, ирцийн мэдээгээ танилцуулъя.

Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч бүрийн итгэмжлэл, биеийн байцаалтыг шалгаж, тулгалт хийв. Ирцийн ажиллагаа 10:00 цагаас эхэлсэн болно.

Тооллогын комиссын дарга Т.Байгалиас: Ирцийн мэдээллийг хуралд танилцуулж, 779,574 ширхэг саналын эрх бүхий хувьцаатай 15 хувьцаа эзэмшигч хуралд хүрэлцэн ирсэн байна. Ирцийн дүн 56,97% байна гэв.

Даргалагчаас: Саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцох хууль зүйн үндэстэй байна. Хурлын дараалал, хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

- Тооллогын комисс ирцийн бүртгэлээ хийж, ирцийн мэдээгээ танилцууллаа
- Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
- ТУЗийн гишүүдийн цалин урамшуулал, төсвийн талаар ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны саналыг хэлэлцэх, батлах
- Ногдол ашгийн хуваарилалтын талаар мэдээлэл, тайлбар сонсох
- Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт, хариултыг тухай бүрт
- Тооллогын комиссоос саналын хуудас тарааж, санал хураалтын ажиллагаа явагдана
- Саналын хуудас тоолох явцад хурлын завсарлага
- Саналын хуудасны дүнг танилцуулна.
- ХЭХ-аас гарах тогтоолын төслийг танилцуулж, батлуулна.
- Хурлыг хаана. Ийм дарааллаар өнөөдрийн хурлыг удирдан явуулна.

Хэлэлцэх асуудлын дараалал болон бусад асуудлаар хувьцаа эзэмшигчдэд асуух болон хэлэх санал хүсэлт байна уу? Хурлын материалыг Монголын Хөрөнгийн Бирж болон өөрийн сайтдаа байршуулсан, үнэт цаасны компаниуд руу мэйлээр явуулсан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг нийтэд мэдээлснээс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд компани дээр хурлын материалыг хэвлэж бэлдсэн байсан боловч хэн ч ирж танилцаагүйг тэмдэглэлд мөн тусгуулъя. Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлаас өмнө шаардлагатай материалтайгаа ирж танилцах бүрэн боломж үргэлж нээлттэй байдаг гэдгийг дахин хэлье. Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэн хэлэлцэх асуудал тус бүрт чөлөөтэй, идэвхтэй асууж, хариулж, сонирхсон бусад зүйлсээ минут харгалзахгүйгээр чөлөөтэй асууж болно.

Оролцогчид: Дараалал, хурлын материалтай танилцсан тул хэлэлцэх асуудалд оруулах саналгүй, асуулт хариултын журмаар явуулахыг дэмжиж байна гэцгээв.

Б.Зоригоос: Надад нэг санал байна, хувьцаа эзэмшигчдийн хуралдаа анх удаа ирж байгаа хүн харагдаж байна, бүгдээрээ танилцъя гэв.

А.Хизатбекээс: Би Баян-Өлгий аймгийн Өлгий суманд оршин суудаг, хувиараа бизнес эрхэлдэг Хизатбек гэдэг хүн байна. Казакстан улс руу гарсан ахан дүүсээ хайж олоод консулын газраас итгэмжлэл хийлгэн, төлөөлөн өнөөдрийн хуралд оролцож байна, Баярлалаа гэв.

Б.Гансүхээс: Миний бие энэ компанийн 238 хувьцаа эзэмшдэг, сүүлийн 3-4 жилд эзэмшиж байгаа, хурал давхцаад, өглөө эрт болдог ч юм уу шалтгаанаар ирж чаддаггүй байлаа. Гансүх гэдэг гэв.

Б.Зоригоос: Бусад хүмүүсийг танилцуулах уу?

Б.Гансүхээс: За бид ч энд тэнд тааралдаад зүс мэддэг болоод байгаа дөө, шаардлагагүй гэв.

Даргалагчаас: Хурлын зарыг СЗХ-оос шинэчлэн батлагдсан журмын дагуу хийж гүйцэтгэсэн. За ингээд хэлэлцэх асуудлын дарааллын талаар асуух асуулт байхгүй бол нэг дэх асуудалдаа оръё. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг миний бие хэлэлцүүлъя /ТУЗ-ийн дүгнэлтийг хавсаргав/.

Даргалагчаас: Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтээс асуух асуулт байна уу?

Ж.Энхтунгалагаас: ББСБ юу болсон бэ?

Даргалагчаас: СЗХ-нд материалаа нэг удаа шалгуулсан байгаа, манай энэ жилийн барааны татан авалттай давхацсан тул санхүүгийн хувьд мөнгөө төвлөрүүлэх боломжгүй болоод хүлээнэж байгаа. Ер нь бол бусад материалын тухайд бэлэн болсон байгаа гэв.

Ж.Энхтуналагаас: Анх 1992 онд хувьчлагдахдаа хэчнээн хувьцаа эзэмшигчтэй байсан юм бол?

Б.Зоригоос: Яг хэд байсныг одоо хэлэх боломжгүй, мэдэхгүй байна гэв.

Даргалагчаас: Тухайн үеийн мэдээ мэдээллээс л харах боломжтой байх, анх бол 1,368,206 хувьцаа гаргаж байсан, өнөөдрийн тухайд 57 брокер дилерийн компанийн 1504 хувьцаа эзэмшигч иргэн, байгууллага байна гэв.

А.Хизатбекээс: Анх бид Материалимпэкс ХК-ийн хувьцааг 500 төгрөгөөр авч байлаа. Сүүлийн жилүүдэд мэдээж үнэ ханш нь өссөн байна. Бид хувьцаагаа ер нь худалдах бодолтой байгаа гэв.

Даргалагчаас: Та хурал тараад уулзаж болно оо, нээлттэй гэв.

А.Хизатбекээс: Танайх ногдол ашиг байнга тарааж байсан уу?

Даргалагчаас: 2008 он хүртэл ер нь тараагдаагүй, тасалдаж байсан, 2008 оноос хойш бага ч гэсэн байнга ногдол ашиг тараадаг байсан. Энэ жилийн ногдол ашгийн мэдээллийг дараалал ёсоор та бүхэнд танилцуулж, тайлбарлах болно.

Б.Гансүхээс ТУЗ-ийн дүгнэлтэд орон сууц худалдан авах ч юм уу ийм байдлаар дэмжих санал бичсэн байна л даа. Энэ талаар тодруулъя, ямар үнэ ханштай юм бэ?

Б.Зоригоос: Манай компанийн хэрэгжүүлж буй төслийн Май таун хорооллын барилга бол нэг м.кв талбайн үнэ 2,4 сая төгрөг байгаа. Энэ үнэ бол Баянгол дүүргийн хэмжээнд бол дундаж үнэ ханш. Төлбөрийн нөхцөлөөс хамаарч дээшлэх доошлох бага зэргийн хэлбэлзэл бий. Бид арматур болон бусад төрлийн зах зээлд нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүнийг дан бэлэн мөнгөөр борлуулна гэдэг өнөөгийн нөхцөлд нийцэхгүй болоод байгаа. Энэ талаар та нар ч мэдэж байгаа байх, бараа солилцоо буюу бартерын асуудал байнга яригдах болсон тул бид бараа бүтээгдэхүүний борлуулалтаа дэмжих зорилгоор барааны тодорхой хувьд бартер хийж, орон сууц авдаг, авсан орон сууцаа эргээд борлуулах ажил хийж байна. Манай компани борлуулалтын албатай, гэсэн хэдий ч бид бартераар авсан байрнуудаа үл хөдлөх хөрөнгө зуучлалын компанитай мөн хамтран ажилладаг. Тухайн компани байрыг зараад зуучлалын хөлс гээд тодорхой хувь авдаг. Энэ хувийг өнөөдөр манай ажиллагсад, хувьцаа эзэмшигч та бүхэн хэн нь ч бай ах дүү, төрөл садан, найз нөхөд нь байр хайж байгаа бол санал болгоод тэр зуучлалын хувийг авах боломж хэнд ч нээлттэй шүү гэсэн санаа. Харин энэ зуучлалын хөлс манай Май таун хорооллын байранд хамааралгүй шүү. Улаанбаатар хотын бараг бүх дүүрэгт байр бий, та бүхэн хэрэв сонирхох бол манай борлуулалтын албатай холбогдоод мэдээлэл авч болно шүү гэв.

Даргалагчаас: Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдэд байрууд байна. Үнэ бол өөр өөр байгаа. Ажлын газрын хамт олон, нутгийн хүмүүстээ санал болгож болно гэсэн санаа.

А.Хизатбекээс: Танай тээвэр зуучлал Казакстан улсаас вагоноор тээвэр хийдэг үү. Бид Барнаулаар дамжуулдаг. Бид шууд тээвэр байдаг гэж мэддэггүй байсан юм байна?

Б.Зоригоос: Хийдэг, та сонирхвол манай тээвэр зуучийнхантай уулзаарай гэв.

Ж.Энхтунгалагаас: Катанг гэж юу байдаг вэ? Бартерын байр гэж зөвхөн арматурын бартерт авсан байр уу?

Б.Зоригоос: Катанг гэж нарийн размеровн ороосон арматур гэж ойлгож болно. Бартерт ганцхан арматур катанг биш, бетон зуурмаг, шил гээд манайхаас гарч байгаа бүтээгдэхүүнүүд аль аль нь байдаг гэв.

Даргалагчаас: Өөр асуух асуулт байна уу?

Оролцогчид: Асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Асуултаа хэдийд ч тавьж болно шүү. Дараагийн хэлэлцэх асуудал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг аудитын хорооны гишүүн Н.Мягмарсүрэнгээс хэлэлцүүлнэ.

Н.Мягмарсүрэнгээс: Аудитын хорооны дүгнэлтийг уншиж хэлэлцүүлэв.

Даргалагчаас: Асуух асуулт байвал асууя.

Ж.Энхтунгалагаас: Аудит гэж танай компанийн дэргэдэх аудит гэж байдаг юм уу?

Ч.Чинзоригоос: ТУЗ маань өөрөө дэргэдээ аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх гээд дэд хороодуудтай байхаар хууль, журамдаа заасан байдаг. Хороодыг хараат бус гишүүд ахалж явдаг байгаа гэв.

Н.Мягмарсүрэнгээс: Хөндлөнгийн аудитын байгууллага гэж тусдаа байдаг. Одоогийн байдлаар манайд Хороонд бүртгэлтэй "Координат аудит" ХХК-иар аудитаа хийлгэж байгаа гэв.

Ж.Энхтунгалагаас: Өр төлбөр ихэссэн харагдаж байна. Яагаад ихсэв?

Н.Мягмарсүрэнгээс: Арматур, цагаан будааны татан авалтад зориулж өнгөрсөн жил Голомт банкнаас 3,7 тэрбум төгрөгийн зээл авсан учраас өр төлбөрийн дүн өссөн байгаа гэв.

Б.Ганболдоос: Зээлийн хүү хэд байна, урт хугацаанд бизнесийн зээл өгч байна уу?

Н.Мягмарсүрэнгээс: 12 сарын хугацаатай, 1.3-1.4 хувийн хүүтэй гэв.

Б.Зоригоос: Ер нь бол бизнесийн зээлийн хүү банкуудад 1,6% байдаг, гэхдээ манайх олон жилийн харьцаатай, итгэл даасан байгууллага гэдгээрээ 0,2%-ийн бага хүүгээр зээл авсан байгаа гэв.

Даргалагчаас: Өөр асуух асуулт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх дараагийн асуудалдаа оръё. Гүйцэтгэх захирлаас 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцүүлъя.

Б.Зоригоос: 2019 оны бизнес төлөвлөгөө бол тодорхой, маш ойлгомжтойгоор хийсэн байгаа. Үнэхээрийн зайлшгүй хийх цаг үеийн шаардлага гарсан хөрөнгө оруулалтыг энэ жил хийхээр төлөвлөсөн. Тухайлбал агуулахын тухайд хуучин агуулахаа буулгаад орчин үеийн стандартад нийцсэн шинэ агуулахын барилгыг эхлүүлэх, нэг жилд бүх агуулахаа барьж амжихгүй учраас дэс дараатай хийхээр төлөвлөсөн. 4 үндсэн чиглэлээр төлөвлөж, өнгөрсөн онд хийгдэж амжаагүй ажлыг хийх, гүйцээх, ТУЗ-өөс үйл ажиллагаанд хийсэн дүгнэлтийг мөн тусгаж төлөвлөсөн, эхнээсээ ажлууд хийгдэж эхэлсэн. Урьдчилсан тооцоолол гаргасан, төсөв бага зэрэг дээшээ доошоо болох байх гээд бизнес төлөвлөгөөг дэлгэрэнгүй тайлбарлан, хэлэлцүүлээд бизнес төлөвлөгөөтэй холбоотой асуух асуулт байвал хариулъя гэв.

Б.Ганболдоос: Худалдааны төвийн барилга барихаар төлөвлөсөн байна. Үүнийг өөрийн хөрөнгөөр барих уу?

Ж.Энхтунгалагаас: Цэцэрлэгийн барилга?

Б.Зоригоос: Энэ цэцэрлэг, худалдааны төвийн барилга бол одоо манай хэрэгжүүлж байгаа Май таун хорооллын барилгын ерөнхий төлөвлөгөөгөөр батлагдсан төсөл. Барилгын ажлыг эхлээгүй байна. Эхлээгүй шалтгаан бол Голден парк руу явах зам барихаар барьцаалж манай барилга эхлүүлэх зөвшөөрлийг өгөхгүй байгаа. Барилгыг бид гаднын хөрөнгө оруулалтаар барихаар хөрөнгө оруулагчаа олсон хэдий ч өнөөг хүртэл дээрх шалтгаанаар барьцаалагдаж гэх юм уу, ажлаа эхлүүлж чадахгүй байгаа. Хөрөнгө оруулагчаа 2-3 жил хүлээлгэсэн, одоо хэдий хугацаанд хүлээх вэ дээ, хөрөнгө оруулагчаа алдах гээд л байна гэв.

Ж.Энхтунгалагаас: Төслийн ерөнхий үнийн дүн хэд вэ?

Б.Зоригоос: Худалдаа үйлчилгээний барилга 40 сая орчим доллар, орон сууцны нэг барилга 12-15 тэрбум төгрөг байдаг. Бид гэрээгээ анх 5 орон сууцаар хийсэн, 4 нь баригдсан. Худалдаа, үйлчилгээний төвийн гэрээ хийгдээгүй, урьдчилсан тооцоогоор 40 сая орчим доллар гэж гарсан байгаа. Би та бүхэн сонирхож байгаа тул зураг харуулъя гээд барилгын төслийн зургийг харуулж тайлбарлаад хойд борлуулалтын албанд макет бий, ороод хараарай гэв.

Даргалагчаас: Нэгэнт Голден паркийн тухай яриа гарсан дээр гүйцэтгэх захирлаас хувьцаа эзэмшигчдийн өмнө асуух асуулт байна. Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас 2019.03.04-нд бичиг ирсэн. Энэ бичигт "Баянгол дүүргийн 4-р хороо, Нарны зам Хермес худалдааны төвийн хойд талаас баруун тийш Голден парк хотхоны урдуур Энхтайваны өргөн чөлөөтэй холбох 0,96 км 1-р зэрэглэлийн туслах

гудамж замын архитектур төлөвлөлтийн даалгавар болон гүйцэтгэх хөрөнгө батлагдсан” гэж байна. энэ бичгээр бол манай хашаан дундуур зам явахаар мэдэгдэл өгөөд байна шүү дээ. Би энэнтэй холбоотой өнөөдөр 15 цагт ЗГХЭГ-ын дарга Оюун-Эрдэнийн хуулийн зөвлөхтэй уулзахаар цаг авсан байгаа. Би бол хашаан дундуураа зам тавиулахгүй гэсэн байр суурьтай байгаа, энэ олон 1500 гаруй хувьцаа эзэмшигчийн хөрөнгө, 60 жил эзэмшиж ашигласан компанийн газарт хотын захиргаа дур мэдэн, хүчээр захирамжлан зам тавих гэж байгааг эсэргүүцдэг. Захиралтай уулзсан юм шиг миний уулзсан хүмүүс ярьдаг, гэтэл захирал болохоор би ТУЗ-ийн болон ХЭ-дийн ямар нэгэн шийдвэргүй ганцаараа шийдэх боломжгүй гэж ярьдаг гэдэг. Гэтэл нөгөө талаас ийм бичиг ирээд байгаад тайлбар өгье.

Б.Зоригоос: Энэ асуудал жил жилийн сонгуулийн үеэр сонгуулийн шоу маягаар яригдаад байдаг байсан. Гэтэл энэ удаад арай өөр зүйл анзаарагдаж байна. Материалимпэксийн захирал тохирсон, зөвшөөрөл өгсөн, энэ дундуур 4 эгнээ зам тавина

Ж.Энхтунгалагаас: Аль дундуур зам тавина гээд байгаа юм бэ?

Б.Зоригоос: Манай компани руу Гермесийн хажуугаар орж ирж байгаа орох үүднээс хашаа дагуулаад Голден парк руу юм гэнэ. Үүнийг нь Материалимпэксийн захирал зөвшөөрсөн гэх яриа явагдаж байна гэдгийг сонсож байсан, одоо ч байна. Баянгол дүүргийн засаг дарга, Эрдэнэ гишүүн, иргэдийн хуралд сонгогдсон Нарантуяа, 4-р хорооны засаг дарга Дорждулам нар өмнөх сонгуулийн үеэр ч ярьж байсан, өнөөдөр маш эрчимтэй ярьж байна. Гэтэл намайг зөвшөөрсөн мэт ярьж, манай ТУЗ-ийн дарга сүүлдээ надад ч итгэх итгэлгүй болж байх шиг байна. Би энэ талаар албан ёсоор тэмдэглэлд тусгуулан хэлмээр байна. БИ ЯМАР Ч ТОХИОЛДОЛД ХУВИЙН ЭРХ АШГАА БОДОЖ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИЙДВЭРГҮЙГЭЭР, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРГҮЙГЭЭР КОМПАНИЙН ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНИЙ ГАЗРЫГ ХЭН НЭГЭНД, ТӨРД Ч БАЙ ДУР МЭДЭН ӨГӨХ ЭРХ МЭДЭЛ НАДАД БАЙХГҮЙ, ИЙМ ЗӨВШӨӨРӨЛ ӨГӨӨГҮЙ ГЭДГИЙГ ХЭЗЭЭД ХЭНД Ч ХЭЛДЭГ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ТА БҮХЭНД Ч ХАРИУЦЛАГАТАЙГААР МЭДЭГДЭЖ БАЙНА. Ийм ч учраас өнөөдрийг хүртэл бид машины зогсоолоо ч, ар талынхаа ч, урд талынхаа ч замаа янзалж чадахгүй байгаа. Ямар учраас яагаад ийм асуудал бүр хотын даргын хэмжээнд хүртэл шат шатанд яригдаад байгааг, яагаад 4 эгнээ зам барихыг миний зүгээс зөвшөөрсөн гээд байгааг бодоод байна. Барилга эхлүүлэх зөвшөөрлөө авахын тулд, орц гарцын асуудлыг нь шийдэхийн тулд уулзахын хувьд өчнөөн уулзаж байсан, олон санал санаачлагыг манай зүгээс гаргаж байсан, санал зөндөө солилцож байсан. Ийм гаргалгаа, гарц байж болох талаар санал хэлдгийг маань намайг зөвшөөрсөн гэж хүнд яриад байдаг юм болов уу л гэсэн бодол байна. Түүнээс би дур мэдэн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэхгүй, хэзээ ч би дангаараа зөвшөөрөл хэн нэгэнд олгохгүй гэдгээ дахин дахин хэлье. Өчигдөрхөн хорооны засаг дарга Аюушмаа гуайд Зориг захирал чинь зөвшөөрчихөөд байхад та ингээд яваад байдаг нь ямар учиртай юм бэ гэж хэлсэн байдаг. Тэгэхээр энэ асуудал цашлаад ноцтой асуудал болж болзошгүй тул хувьцаа эзэмшигчид энэ талаар мэдээлэлтэй байх нь зөв. Энэ талаарх саналаа бас та бүхэн хэлээрэй гэв.

Даргалагчаас: Компанийн орлого буураад байгаа шалтгаан бол манай гадна тохижилт, зам талбай, тоосжилттой шууд холбоотой. Голден парк хотхон баригдсанаас хойш олон олон сөрөг асуудал хөрш зэргэлдээ манай байгууллагад гарч байгаа. Осол аваар, хулгайн гэмт хэрэг гээд асуудал дагуулсан зүйл зөндөө байна.

Г.Гансүхээс: Манай компанийн хашаагаар оршин суугчид орж гардаг гэсэн үг юм уу? Ийм зүйл байж болох уу?

Б.Зоригоос: Тийм ээ, бид өнөөдрийг хүртэл оршин суугчдын эрх ашгийг бодож хашаагаа битүүмжилж чадахгүй, осол аваар дунд, олон арван асуудал дунд ажиллаж байна. Голден паркаас байр авсан хүмүүсийн буруу биш шүү дээ, энэ хандлагаар бид хүлээцтэй хандаж ирсэн. Энэ хугацаанд вагонтой машин мөргөлдөх осол 4 удаа, вагон доор сэлгээ хийх хооронд согтуу хүн ороод хэвтсэн байсан асуудал хүртэл байна, хүний

амь нас эрсдэх аюул бэлэн байна. Эцсийн бүлэгт асуудал гарахад хэнд хариуцлага тооцох юм бэ, мэдээж манай эзэмшлийн хашаа гээд манайд л хариуцлага тооцно. Өнөөдөр энүүгээр яваа оршин суугчид, иргэдэд хэн ч хариуцлага тооцохгүй.

Оршин суугчид хогоо шатаах, хогоо хашаа давуулж шидэх, машинаасаа хашаан дотор явах замдаа хогоо хаях, хүүхдүүд арматур, катанг дундуур тоглох, гүйх, авирах, гээд жижиг гэлтгүй асуудал өдөр бүр гарч байдаг гэв.

Г.Гансүхээс: Бусдын буруутай үйлдлийг, өөрөөр хэлбэл Голден парк хотхоныг барьсан компанийн хийх ёстой ажлыг яагаад манай компани гүйцээх ёстой, газраа өгөх ёстой юм бэ. Энэ асуудал дээр эсэргүүцэж байна, энэ газар хувьцаа эзэмшигч бидний эзэмшиж ашиглаж байгаа газар мөн. Үүнийг тэмдэглэлд заавал оруулаарай. Зам барихын эсрэг байна гэв.

Даргалагчаас: Шүүхийн шийдвэр гарсан газарт л барилга бариад, мэргэжлийн хяналт, шүүхийн шийдвэр биелүүлэх газар, зогсоохгүй, хүчээр бариулсаар байгаад тэр барилгыг нь мэргэжлийн хяналтын байгууллага хүлээн авсан гээд ярих юм бол дуусахгүй их тайлбар, баримт, нотолгоо бидэнд бий. Худал хуурмаг зүйл хийсэн төрийн байгууллагын нөхдүүд өнөөдөр дарга болоод дэвшээд яваад байдаг, бид энд шорондоо хутгалдаад суугаад байдаг. Хэлж яриахаар оршин суугчдын эрх ашиг гэж ганцхан зүйл хэлдэг. Гэтэл манай хувьцаа эзэмшигчид, ажилчид, үйлчлүүлэгчид бас хүн шүү дээ. Өнөөдөр Голден паркийн 6800 гаруй хүмүүсийн эрх ашиг гэдэг, гэтэл манай хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчид, ажиллагсад хэд болох вэ, бас л нэг тоо гарна. Хэний эрх ашгийг тэргүүн ээлжинд тавиад хэний эрх ашгийг дараачийнх гэж үзэж дугаарлаад байгааг юм бэ. Бид бодох л асуудал. Энэ талаар хувьцаа эзэмшигчид та бүхэн саналуудаа хэлж, ТУЗ-д, гүйцэтгэх захиралд үүрэг, чиглэл өгсөн ч болно. Та бүхэн хэрхэх саналуудаа хэлээрэй.

Б.Зоригоос: Өнөөдөр шинээр ирсэн хувьцаа эзэмшигчид гайхаж байж магад, өмнө нь ирж байсан эздүүд мань энэ талаар сайн мэдэх байх. Товчдоо Голден парк 2 гээд байгаа энэ хотхон ерөнхий төлөвлөгөөгүй, барилга эхлэх зөвшөөрөлгүй баригдсан, орц гарцгүй баригдсан. Голден парк-2-ын оршин суугчид Материалимпэксийн хашаагаар орж гардаг, бид хэрэв хашаагаа хаачих юм бол оршин суугчид орох гарах газар байхгүй. Энэ хотхон 2012 оны 12 сард ашиглалтад орсон байдаг, бид өнөөдөр хүртэл хүлээцтэй хандсаны бас нэг шалтгаан бол энд оршин суугчид иргэдийн буруу гэж байхгүй, засаг төр, хотын эрх бүхий байгууллага ямар нэгэн байдлаар орц гарцны асуудлыг нь шийдээд өгөх байх гэсэн байдлаар олон жил хүлээж, олон олон санаачлага гаргасаар ирэхэд одоо сүүлдээ заавал танай энүүгээр зам тавина, тэгэхгүй бол танай барилга эхлүүлэх зөвшөөрөл өгөхгүй гэж барьцаалах хэлбэрт орж байна. Асуудал гарах бүрт хаалгаа хаая, хашаагаа битүүмжилье гэхээр гал гарвал яах вэ, хүн төрвөл яах вэ, түргэний машин хаагуур орох вэ гэдэг байдлаар бид хандсаар ирсэн гэв.

Даргалагчаас: Батлагдсан ерөнхий төлөвлөгөө хэрэгжихгүй, барилгын ажил үргэлжлэхгүй байна. Бид тэгтэл газрын төлбөрийг бүрэн төлж байгаа. Газраа бүрэн ашиглаж чадахгүй байна аа гэсэн үг. Газрыг эзэмшиж ашиглах боломжийг маань төрийн байгууллагаас хааж, боогоод байна.

Т.Мөнхжаргалаас: Надад нэг санал байна, тэр Голден парк, Цоглог хотхоны тэрүүгээр гаргасан хэсгийг хаачихвал яасан юм бэ. Одоо бид нэгэнт хүчрэхээ байвал яах юм бэ, төр төмөр нударгаа харуулаад хүчээр бариад эхлэвэл хэн хохирох вэ. Энэ хаалт онгорхой байгаагаас ямар олон сөрөг үр дагавар байгааг хэн хүнгүй мэднэ. Би хувьцаа эзэмшигчдээсээ бас асуумаар байна. Тэр хаалгаа хаая гэсэн санал оруулж байна гэв.

Ж.Энхтунагалаас: Дэмжиж байна, бусдын бурууг бусдаар нөхүүлэх ёсгүй. Ер нь бол гаалийн хяналтын бүс, гаалийн баталгаат агуулах миний мэдэхээр онцгой бүс байдаг, гэтэл ийм замбараагүй байж болохгүй. Холбогдох газруудад нь энэ өнөөдрийн байдлаа нэгбүрчлэн маш тодорхой бичиж, хэн ч уншсан сэртхиймээр асуудалд хандаж, одоо онгорхой байгаа хаалтаа хаая гэв.

Бусад оролцогчдын 100%-ийн саналаар Голден парк руу Материалимпэксээр дамжих хаалт хаахыг дэмжив.

Даргалагчаас: Энэ талаар тусгайлсан тогтоол бол гарахгүй, хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй асуудал учраас. Энэ асуудлыг мэдээллийн чанартай хувьцаа эзэмшигчиддээ хэлж, эздүүдийн снэл, хүсэлтийг сонсож байгаа юм шүү. Тогтоол, шийдвэр гаргаж байгаа биш гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Өөр асууж тодруулах зүйл, санал байна уу?

Ж.Энхтунгалагаас: Компани руу ордог хэсгийнхээ явган замыг цааш нь үргэлжүүлвэл яасан юм бэ, машин зам явган зам нь нийлчихсэн, нэл шороотой замаар явахад ч бэрхшээлтэй харагддаг гэв.

Даргалагчаас: Тэмдэглэлдээ тусгаад та бүхний саналуудыг аль болох биелүүлэх, хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ ээ. Санал байвал хэлээд байгаарай.

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлын дараалал ёсоор ТУЗ-ийн 2019 оны төсөв, гишүүдийн цалин урамшууллыг хэмжээг тогтоох асуудлыг Цалин урамшууллын хорооны дарга Ч.Чинзоригоос хэлэлцүүлье.

Ч.Чинзоригоос: Өөрийгөө танилцуулаад, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос компанийн өмнөх жилүүдийн төсөв, төлөвлөгөөнүүдийг судалж үзээд 2018 онд ТУЗ тусгайлсан төсөв гэж тусгахгүй байя, үйл ажиллагааг сайжруулах чиглэлийг дэмжие, тусгайлсан томилолтын болон сургалтын зардал тусгахгүй байя гэсэн санал дээр нэгдсэн байгаа. Харин 2019.01.01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой ТУЗ-ийн гишүүдийн нэг сарын цалин, урамшууллын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан бүр доод хэмжээгээр биш 350,000 төгрөгөөр тогтоовол яасан юм бэ гэсэн саналыг оруулж байна. Та бүхэнд асуух асуулт байвал хариулахад бэлэн байна гэв.

Бүх оролцогчид: Дэмжиж байна, асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлын дараагийн асуудал ногдол ашгийн талаар мэдээлэл хийнэ. Зориг захирал тайлагнах уу?

Б.Зоригоос: Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн санхүү, үйл ажиллагааны тайлан, 2019 оны төлөвлөгөөний урьдчилсан байдлыг харж, хэлэлцээд 2018 оны үйл ажиллагааны ашгаас хувьцаа эзэмшигчдэд 2019 онд ногдол ашиг хураарилахгүй байя гэж хэлэлцээд 2019.02.18-ны өдрийн 04 тоот тогтоол гарсан байгаа. Хэдийгээр компани 2018 онд 612 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан хэдий ч сүүлийн жилүүдэд компани руугаа чиглэсэн хөрөнгө оруулалт хийсэнгүй, өнөөдөр манай агуулах талбай, краны их бүрэн засвар үйлчилгээг хийх зах зээлийн, цаг үеийн шаардлага байна. Олон талаас нь ТУЗ дээр ярьсан. Өнөөдөр нэгж хувьцаанд ноглох ашгийн хэмжээ 10 төгрөг ч юм уу тэ нэг хувьцаа эзэмшигчид очих үр өгөөж багатай, эргээд компанидаа үлдээгээд нэг ч гэсэн агуулахаа шинэчлээд түрээслэвэл эдийн засгийн өгөөж нь илүү хэрэгтэй юм уу гэсэн байдлаар ногдол ашиг хавууриалхгүй байх нь зүйтэй гэдэгт санал нэгдсэн юм шүү. Компанийнхаа хөрөнгө оруулалтыг дэмжье гэсэн санаа гэв.

А.Хизатбекээс: Ногдол ашгаа компанидаа үлдээе гэсэн санаа юу?

Б.Зоригоос: Тийм ээ, хөрөнгө оруулалтаа дэмжье гэдэг байдлаар хуваарилахгүйгээр тогтсон гэв.

Даргалагчаас: Бид хөрөнгө оруулалтаа зөв хийж чадаад үр шимийг нь авч чадвал илүү ашигтай ажиллахад эргээд хувьцаа эзэмшигчдэд маань ашигтай байх болов уу гэж харсан.

А.Хизатбекээс: Зөв өө, компанидаа үлдээх хэрэгтэй, олсон бүгдээ тараагаад байж болохгүй, зарим жилдээ тарааж, зарим жилдээ компани ашиглах нь зөв гэсэн санаа хэлэх гэсэн юм. Мөн компани дээрээсээ ногдол ашиг тарааж болох уу? Үнэт цаасны газраас өндөр татвар авдаг юм байна гэв.

Н.Мягмарсүрэнгээс: Ер нь бол татварыг компани дээрээс тараасан ч ХХОАТ суутгагддаг юм шүү. Гэхдээ СЗХ болон хөрөнгийн биржээс өгдөг чиглэл бол компани

дээрээсээ тараахаа боль, заавал үнэт цаасны компаниар тараа гэдэг шаардлага тавьдаг гэв.

Даргалагчаас: Ногдол ашгийн талаар болон хэлэлцсэн асуудлын талаар асуух асуулт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудал, мэдээллийн чанартай сонсох асуудлууд дууслаа. Хувьцаа эзэмшигчдэд асуух асуулт байна уу? Асуулт хариултдаа орцгооё.

Оролцогчид: Асуух асуулт байхгүй, тухай бүрт асуусан учраас асуултгүй гэв.

Даргалагчаас: Саналын хуудсыг тарааж, санал хураалтдаа оръё.

Тооллогын комиссын гишүүд саналын хуудсыг тарааж комиссын дарга Т.Байгалиас бөглөх зааврыг тайлбарлан өгөв.

Санал хураалт 5 минут үргэлжлэв.

Тооллогын комиссын гишүүд саналын хуудсыг хураан авч санал хураалтыг тоолох ажлыг эхлүүлэв.

Даргалагчаас: Саналын хуудсаар дүнг тоолж байх хугацаанд хувьцаа эзэмшигчдийнхээ санал, хүсэлтийг сонсож байя.

Оролцогчид: Байхгүй байна гэцгээв.

Даргалагчаас: Хэлэлцсэн асуудлуудтай холбоотойгоор нэмж гаргах санал, хүсэлт, асуулт байна уу?

Бусад оролцогчид: Асуух асуултгүй, нэмж хэлэх санал байхгүй байна гэв.

Тооллогын комиссын дарга Т.Байгалиас: Тооллогын дүнгийн тухай комиссын тогтоол уншиж танилцуулав. Утга нь:

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт, Аудитын хорооны дүгнэлт, компанийн 2019 оны бизнес төлөвлөгөө, ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах талаар бичгээр санал хураахад нийт **779,574** саналын эрхтэй хувьцааны **15** ширхэг хуудас тоолсон дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тооллогын комиссын саналын хуудсыг шалгахад **15** хуудас гарснаас **15** хуудсыг хүчинтэйд тооцож,

2. Хүчинтэйд тооцогдсон саналын хуудсаар дүгнэхэд хэлэлцүүлж буй асуудлыг доорхи хувиар зөвшөөрснийг тогтоов. Үүнд :

2.1 Компанийн 2018 үйл ажиллагааны болон санхүүгийн байдалд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг баталсан 100 хувь

2.2 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг баталсан 100 хувь

2.3 Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг зөвшөөрч, баталсан 100 хувь

2.4 ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, баталсан 100 хувь.

Даргалагчаас: Тооллогын комиссын дүнтэй холбоотой асуух асуулт байна уу?

Оролцогчдоос: Байхгүй гэв.

Даргалагчаас: Тооллогын комиссын тогтоолыг үндэслээд өнөөдрийн ХЭХ-аас дараах 2 тогтоол гарч байна. Тогтоол №01 утга:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2019 оны 04 сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02, Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталж,
2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган хувьцаа эзэмшигчдээс гаргасан санал шүүмжлэл, санаачлагыг үйл ажиллагаандаа тусган зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгаад,
3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгов.

Тогтоол №02. Утга:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, 2019 оны 04 сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэг гишүүний нэг сарын цалин, урамшууллын хэмжээг 350,000 /Гурван зуун тавин мянган/ төгрөгөөр тогтоож, батлан,
2. Энэхүү тогтоолыг 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.

Даргалагчаас: Хурлаас гарч буй тогтоолыг ХЭ-дээсээ гар өргөж давхар баталгаажуулъя. Тогтоол №01, 02-ыг батлах уу?

Бүх гишүүд: 100% гар өргөн батлав.

Даргалагчаас: Ингээд хуралдаа ирж оролцсон та бүхэнд баярлалаа. Хурал хаахаас өмнө хэлэх санал, хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэснээр хурал 12 цаг 15 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТУЗ-ИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ХУРЛЫН ДАРГА

Т.ЛХАГВАЧУЛУУН

Г.АЮУШМАА

